

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/79/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 70432545 цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>СТА</i>	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>
<i>ЭМГ</i>	<i>Эрүүл мэндийн газар</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	10
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа:	15
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	Error! Bookmark not defined.
2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	17

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав Сан, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433051, факс: 976-70433051
E-mail: khovd@audit.gov.mn

ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ДӨЛБАДРАЛ ТАНАА

2021.03.12 № 4/60
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлсэн хяналт, шалгалтын үр нөлөө, газар олголтын байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Техник хяналтын зардлыг шатахууны толаны дансаар дамжуулан авч данс бүртгэлд тусгаагүй, байгууллагын нярвын дансаар томилолтын мөнгө, данс андуурч орсон орлогыг гаргаж бусад зүйлд зарцуулсан, бараа материалын үнийг нярвын дансаар дамжуулан авч даргын хувийн харилцах дансанд шилжүүлсэн, хөдөө ажлаар яваагүй байхад замын хуудсыг хөдөө явсан гэж хуурамч баримт бүрдүүлсэн, өөрийн эзэмшлийн хөрөнгийг бусдад ашиглуулсан, үнэт цаасны тооцоо бодоогүй, төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг зөрчин байгууллагын даргын тушаалыг буруу дугаарласан, шүүхийн шийдвэрээр цалин олгосон, И баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн, санхүүгийн тайлан дахь тоон мэдээллүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 "6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог үнэн зөв, шударга

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг тус тус зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,367,096.00	24,415,551.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	125,650.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	125,650.00	00.00
3121	Төгрөг	125,650.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	125,650.00	00.00
33	АВЛАГА	594,985.00	4,425,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	4,000,000.00
335	Бусад авлага	594,985.00	425,000.00
3351	Байгууллагаас авах авлага	594,985.00	425,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,646,461.00	19,990,551.00
351	Түүхий эд материал	3,999,160.00	1,707,350.00
35110	Тусгай зориулалттай материал	3,999,160.00	1,707,350.00
354	Хангамжийн материал	18,647,301.00	18,283,201.00
35410	Бичиг хэргийн материал	5,668,336.00	4,327,336.00
35420	Аж ахуйн материал	11,174,665.00	12,194,565.00
35430	Сэлбэг хэрэгсэл	18,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	1,786,300.00	1,761,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,065,677,113.80	999,212,260.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,065,677,113.80	999,212,260.34
392	Биет хөрөнгө	1,007,571,780.62	941,282,927.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	814,830,700.00	814,830,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,977,072.52	-31,954,145.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,789,800.00	113,789,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,372,222.21	-22,337,188.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	387,082,950.76	392,790,601.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-303,505,590.13	-346,087,954.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,257,720.86	30,535,520.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,825,375.05	-24,110,901.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,870,576.80	15,860,576.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-579,707.89	-2,034,082.41
393	Биет бус хөрөнгө	58,105,333.18	57,929,333.14
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-674,666.82	-850,666.86
39303	Бусад биет бус хөрөнгө	57,900,000.00	57,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,089,044,209.80	1,023,627,811.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,089,044,209.80	1,023,627,811.34
51	Засгийн газрын хувь оролцоо	1,089,044,209.80	1,023,627,811.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,822,164.94	254,822,164.94
51101	Өмч: - төрийн	254,822,164.94	254,822,164.94
512	Хуримтлагдсан үр дүн	832,918,454.89	767,502,056.43
51210	Өмнөх үеийн үр дүн	832,918,454.89	832,918,454.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-65,416,398.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,303,589.97	1,303,589.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,089,044,209.80	1,023,627,811.34

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	816,578,099.67	878,330,693.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,834,266.00	179,333,247.00
120	Нийтлэг татварын бус орлого	162,834,266.00	179,333,247.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,961,266.00	179,333,247.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,660,066.00	168,927,047.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,167,300.00	9,146,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,133,900.00	1,260,000.00
120009	Бусад орлого	58,873,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	252,538,433.67	195,154,146.67
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	401,205,400.00	503,843,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,981,821.00	151,706,760.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	24,607,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,981,821.00	127,099,760.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,771,800.00	39,331,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,771,800.00	39,331,600.00
1330	Төсвийн захирагчдаас	15,784,812.67	4,115,786.67
133003	Хөрөнгийн	15,784,812.67	4,115,786.67
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	723,736,509.94	943,592,118.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,736,509.94	943,592,118.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,850,993.94	691,337,476.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,622,057.00	384,520,123.00
210101	Үндсэн цалин	311,882,057.00	384,520,123.00
210105	Гэрээт ажлын хөлс	740,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,239,946.00	48,126,016.00
210201	Тэтгэврийн даатгал	26,972,335.00	33,261,918.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,074,392.00	3,808,047.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,459,514.00	3,046,437.00
210204	Ажилгүйдлийн даатгал	612,156.00	728,148.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,121,549.00	7,281,466.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,485,700.00	39,290,900.00
210302	Түлш, халаалт	27,575,492.00	33,160,050.00
210303	Цэвэр, бохир ус	3,710,208.00	5,630,850.00
210304	Байрны түрээс	1,200,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,469,909.43	40,215,429.67
210401	Бичиг хэрэг	13,157,270.43	13,670,639.67
210402	Тээвэр, шатахуун	12,881,440.00	20,757,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	330,900.00
210404	Ном, хэвлэл	1,720,500.00	2,641,810.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,426,600.00	2,814,650.00
210408	Бараа материал акталсны зардал	4,923,099.00	00.00
2105	Нормативт зардал	1,700,150.00	870,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,700,150.00	870,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,390,179.00	3,739,000.00
210604	Урсгал засвар	18,390,179.00	3,739,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,112,700.00	13,490,300.00
210702	Дотоод албан томилолт	9,112,700.00	13,490,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,056,350.00	24,554,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,763,000.00	23,076,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	37,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,600.00	430,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	37,825,150.00	1,010,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,774,002.51	136,530,908.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,166,064.00	54,679,377.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,173,296.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,434,642.51	81,851,531.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,885,516.00	252,254,642.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,481,800.00	16,882,300.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,481,800.00	5,827,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,055,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	4,575,400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,575,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,124,600.00	52,428,060.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,124,600.00	52,428,060.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,279,116.00	178,368,882.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,279,116.00	178,368,882.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	92,841,589.73	-65,261,425.13
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	154,973.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	154,973.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-154,973.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	92,841,589.73	-65,416,398.46

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	807,146,074.00	886,228,443.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	157,929,266.00	178,243,232.00
120	Нийтлэг татварын бус орлого	157,929,266.00	178,243,232.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,066,766.00	178,243,232.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,660,066.00	169,206,232.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,406,700.00	9,037,000.00
120009	Бусад орлого	77,862,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	649,216,808.00	707,985,211.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	401,205,400.00	503,843,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	203,981,821.00	164,695,522.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	37,595,762.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,981,821.00	127,099,760.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,771,800.00	39,331,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,771,800.00	39,331,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,257,787.00	114,789.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	11,257,787.00	114,789.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	673,696,942.00	870,812,442.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673,696,942.00	870,812,442.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,795,439.00	618,430,011.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,670,400.00	381,158,600.00
210101	Үндсэн цалин	242,199,300.00	293,309,700.00
210102	Нэмэгдэл	45,518,000.00	58,852,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,170,600.00	10,170,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,782,500.00	18,826,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,083,900.00	51,327,610.00
210201	Тэтгэврийн даатгал	26,577,000.00	36,598,810.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,126,700.00	3,682,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,501,400.00	2,945,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	625,400.00	736,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,253,400.00	7,364,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,485,700.00	39,140,900.00
210302	Түлш, халаалт	27,575,492.00	33,160,050.00
210303	Цэвэр, бохир ус	3,710,208.00	5,480,850.00
210304	Байрны түрээс	1,200,000.00	500,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	12,989,300.00	28,954,390.00
210401	Бичиг хэрэг	1,153,400.00	5,409,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,119,900.00	19,968,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	330,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,355,000.00	3,245,700.00
2105	Нормативт зардал	2,476,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,476,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,253,270.00	190,700.00
210604	Урсгал засвар	17,253,270.00	190,700.00
2107	Томилолт, зочны зардал	9,112,700.00	13,490,300.00
210702	Дотоод албан томилолт	9,112,700.00	13,490,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,316,700.00	41,655,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,763,000.00	23,188,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	37,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,600.00	430,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	57,085,500.00	17,998,762.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,407,469.00	62,115,949.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,234,173.00	62,115,949.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,173,296.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,901,503.00	252,382,431.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,497,787.00	17,010,089.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	11,257,787.00	114,789.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,240,000.00	5,840,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,055,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	4,575,400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,575,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,124,600.00	52,428,060.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,124,600.00	52,428,060.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,279,116.00	178,368,882.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,279,116.00	178,368,882.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	133,449,132.00	15,416,001.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	133,323,482.00	15,541,651.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	133,323,482.00	15,541,651.00
2200	Дотоод эх үүсвэрээр	133,323,482.00	15,541,651.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	133,323,482.00	15,541,651.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	133,323,482.00	-15,541,651.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	125,650.00	-125,650.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	125,650.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	125,650.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,407,811.73	739,972,643.40	996,202,620.07
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	104,221.76	104,221.76
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,822,164.94	1,407,811.73	740,076,865.16	996,306,841.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	92,841,589.73	92,841,589.73

C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	832,918,454.89	1,089,044,209.80
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	832,918,454.89	1,089,044,209.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	832,918,454.89	1,089,044,209.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-65,416,398.46	-65,416,398.46
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	767,502,056.43	1,023,627,811.34

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	543,174,900.00	538,599,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	543,174,900.00	538,599,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	529,879,600.00	525,304,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,219,600.00	368,219,600.00
210101	Үндсэн цалин	280,370,700.00	280,370,700.00
210102	Нэмэгдэл	58,852,100.00	58,852,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,170,600.00	10,170,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,826,200.00	18,826,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,709,700.00	49,709,700.00
210201	Тэтгэврийн даатгал	34,980,900.00	34,980,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,682,200.00	3,682,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,945,800.00	2,945,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	736,500.00	736,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,364,300.00	7,364,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,140,900.00	39,140,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,001,500.00	00.00
210302	Түлш, халаалт	29,781,500.00	33,160,050.00
210303	Цэвэр, бохир ус	5,357,900.00	5,480,850.00
210304	Байрны түрээс	00.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,642,800.00	18,642,800.00
210401	Бичиг хэрэг	5,409,000.00	5,409,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,517,800.00	11,517,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,000.00	361,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,355,000.00	1,355,000.00
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	190,700.00	190,700.00
210604	Урсгал засвар	190,700.00	190,700.00
2107	Томилот, зочны зардал	17,372,700.00	12,797,300.00
210702	Дотоод албан томилот	17,372,700.00	12,797,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	468,200.00	468,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	37,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,600.00	430,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35739000.00	35739000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,739,000.00	35,739,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13295300.00	13295300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,295,300.00	13,295,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,240,000.00	2,240,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,055,300.00	11,055,300.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	543,174,900.00	538,599,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	503,843,300.00	499,267,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	503,843,300.00	499,267,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,331,600.00	39,331,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	39,331,600.00	39,331,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	34	34
620003	Үйлчлэх ажилтан	3	3

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	293,102,108.00	160,810,311.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,102,108.00	160,810,311.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,381,721.00	104,667,462.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	12,939,000.00
210101	Үндсэн цалин		12,939,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,617,910.00
210201	Тэтгэврийн даатгал		1,617,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,314,100.00	10,341,690.00
210402	Тээвэр, шатахуун	5,314,100.00	8,450,990.00
210404	Ном, хэвлэл	30,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,890,700.00
2105	Нормативт зардал	2,080,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,080,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,967,170.00	-
210604	Урсгал засвар	16,967,170.00	-
2107	Томилолт, зочны зардал	6,180,000.00	693,000.00
210702	Дотоод албан томилолт	6,180,000.00	693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,763,000.00	41,187,362.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,763,000.00	23,188,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		17,998,762.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	177,077,451.00	37,888,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	168,904,155.00	37,888,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,173,296.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,720,387.00	56,142,849.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,720,387.00	56,142,849.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	11,257,787.00	114,789.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		3,600,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	35,124,600.00	52,428,060.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,338,000.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	293,102,108.00	160,810,311.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	293,102,108.00	160,810,311.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	89,120,287.00	37,710,551.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,981,821.00	123,099,760.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Э.Дөлбадрал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын зардлын бүртгэл, үндсэн хөрөнгийн бүртгэл, и баримтын бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-наас 2021 оны 03 дугаар сарын 12–ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2020 онд аймгийн “ХАРИУЦЛАГАТАЙ ТУНГАЛАГ ТӨР” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг ард иргэдэд цогц хэлбэрээр тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор “ИРГЭН ТӨВТЭЙ, ИЛ ТОД, УХААЛАГ” газрын харилцааны жил болгон зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “асоулюс” программ хангамж ашигладаг байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2020 онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2018, 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 7734.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3998.3 мянган

төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар 7 төлбөрийн акт тогтоож 3735.8 мянган төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна. Тус акт болон албан шаардлагыг биелүүлэх хугацаа болоогүй байгаатай холбоотойгоор 2020 онд ямар нэгэн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 816578.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8165.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 878330.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8783.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65416.39 мянган төгрөгөөр буюу 6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	125.65	0.00	-125.65	-100%
Авлага	594.98	4,425.00	3,830.02	644%
Бараа материал	22,646.46	19,990.55	-2,655.91	-12%
Үндсэн хөрөнгө	1,065,677.11	999,212.26	-66,464.85	-6%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,089,044.20	1,023,627.81	-65,416.39	-6%
Богино хугацаат өр төлбөр			0.00	0%
Цэвэр хөрөнгө, өмч	1,089,044.20	1,023,627.81	-65,416.39	-6%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,089,044.20	1,023,627.81	-65,416.39	-6%

Авлага дансны үлдэгдэл 4425.0 мянган төгрөг болж өмнөх оноос 3830.02 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлагыг бүрэн барагдуулан ажиллаж барилгын материалын шинжилгээний авлага 425.0 мянган төгрөг, нэмэлт данснаас төсөвт төвлөрүүлсэн 4000.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19990.55 мянган төгрөг болж 2655.91 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд дээд шатны байгууллагаас 4115.78 мянган төгрөгийн хангамжийн материал, бусад байгууллагаас 1260.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч төсвийн хөрөнгөөр 45764.33 мянган төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 53796.02 мянган төгрөгийн бараа материалын зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1089044.20 мянган төгрөг, оны эцэст 1023627.81 мянган төгрөг болж 66464.85 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны өөрчлөлт нь төсвийн хөрөнгөөр 15541.65 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч тооллогоор дутагдсан 566.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж тайлант оны элэгдлийн зардал 81851.53 мянган төгрөгөөр бууруулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1023627.81 мянган төгрөг болж тайлант онд 65416.39 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 65416.39 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 61752.59 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 61752.59 мянган төгрөгийн орлогоос үндсэн үйл ажиллагааны орлого 96266.98 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 1978.9 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 102637.9 мянган төгрөгөөр, орон нутгаас авах санхүүжилт 6559.8 мянган төгрөгөөр нэмэгдэж үнэгүй орлого 22873.9 мянган төгрөгөөр, бусад орлого 58873.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 52275.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 11669.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 219855.6 мянган төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 80784.1 мянган төгрөг буюу 22.9 хувиар, тогтмол зардал 6805.2 мянган төгрөг буюу 20.9 хувиар, хангамж бараа материалын зардал 5745.5 мянган төгрөг буюу 16.7 хувиар, томилолтын зардал 4377.6 мянган төгрөг буюу 48 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 25756.9 мянган төгрөг буюу 23.2 хувиар, урсгал шилжүүлэг 133369.1 мянган төгрөг буюу 112.18 хувиар өсөж нормативд зардал 830.1 мянган төгрөг буюу 48.8 хувиар, эд хогшил урсгал засварын зардал 14651.2 мянган төгрөг буюу 79.7 хувиар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 21501.6 мянган төгрөг буюу 46.6 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд хаасан ямар нэгэн бичилт байхгүй айна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллага нь 2020 онд Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан ГЗБГЗГ-с ирсэн хуваарийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилтээр 503843.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт орон нутгийн төсвөөс 40453.9 мянган батлагдсан боловч аймгийн төсвийн тодотголоор 1122.3 мянган төгрөг хасагдаж санхүүжилт бууруулан 39331.6 мянган төгрөгөөр, нийт санхүүжилтийг 543174.9 мянган төгрөгөөр бүртгэн тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын санхүүжилтээр 503843,3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 39331,6 мянган төгрөгийг төсвөөс төлөвлөжээ. Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 503843.3 мянган төгрөг авч төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 4575.4 мянган төгрөгийг албан томилолтын зардлаас хэмнэж оны эцэст улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	Газрын зураглал, кадастр /71504/	4575.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4575.4
	Нийт дүн	4575.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2019 оны Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан барилгын захиалагчийн техник хяналтын зардалд 60000.0 мянган төгрөг, А/10 дугаар тушаалын дагуу урамшуулал 3600.0 мянган төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр орон нутагт хэрэгжиж буй барилга угсралт их засварын ажлын техник хяналтын зардал 8450.0 мянган төгрөг, орон нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт хийхээр Аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан 11100.0 мянган төгрөг мөн бусад орлого буюу нийгмийн даатгалын сангаас 114.8 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 52428.1 мянган төгрөг газрын дуудлага худалдааны дэнчин 15325.4 мянган төгрөг, харуул хамгаалалтын ажлын хөлс 50% Мерси кор төсөл, Гадаадын иргэн харьяатын газраас 8557.0 мянган төгрөг, бусад орлого 5235.0 мянган төгрөг, нийт 164810.3 мянган төгрөг бүрдүүлжээ.

73717Цалингийн зардалд 12939.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1617.9 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 8450.9 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авахад 1890.7 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 693.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 41187.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 37888.5 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 56142.8 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 4000.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ. .

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6194.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдөж 2016.6 мянган төгрөгийн техник хяналтын зардлыг бусад зардал зарцуулахгүй байх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	701.2	1	701.2	0	0	100
Албан шаардлага	1	537.9	1	537.9	0	0	100
Зөвлөмж	3	4955.5	2	2938.9	1	2016.6	50
Нийт дүн	5	6194.6	4	4178	1	2016.6	83.3

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 84707.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3883.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичиж, 75608.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага бичиж 5215.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж бичлээ.

Залруулсан алдаа:

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 79491.7 мянган төгрөгийн 4 алдаанд 3883.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичигдэж 75608.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага бичигдлээ. Үүнд:

- Пламбинг дэволюмент ХХК-ийн 03/2020 гэрээний 1000.0 мянган төгрөгийн техник хяналтын зардлыг ХААН банканд дахь 5866009296 тоот тансанд шилжүүлэн авсанд төлбөрийн акт бичигдлээ.
- Бараа материалын үнэ гэж төсвөөс байгууллагын нярвынх дансаар гаргаж дарга Э.Дөлбадралын хувийн харилцах данс руу 690.0 мянган төгрөг шилжүүлсэн шилжүүлсэнд төлбөрийн акт бичлээ.
- Шатахууны тайлангаар хөдөө ажлаар яваагүй байхад явсан гэж жолоочийн замын хуудас бичиж 1527.8 мянган төгрөгийн шатахуун зарлагадсан тул төлбөрийн акт бичигдлээ.
- Нярав Б.Дариймаагийн дансаар томилот, андуурч орсон орлого болох нийт 665.5 мянган төгрөгийг гарган авсанд төлбөрийн акт бичигдлээ.
- Тухайн байгууллагын эзэмшилд байгаа 68989.8 мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг зөрчин бусдад ашиглуулсан тул албан шаардлага бичигдлээ.
- Үнэт цаасны тооцоо бодоогүй байгаа тул албан шаардлага бичлээ.
- Байгууллагын даргын А, Б тушаалуудыг дугаарлахтай Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг зөрчин дугаар алсгасан байгаа тул бичиг хэргийн ажилтанд хариуцлага тооцуулах албан шаардлага бичлээ.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 5215.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц техник хяналтын зардлын гүйцэтгэлийг цаг хугацааны хувьд шалгах боломжгүй байсан тул дараагийн аудитаар нягтлан шалгах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлыг бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант онд шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд 3715.5 мянган төгрөгийг гарган өгсөн байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, төлөвлөгдөөгүй зардал гарсан нь өг үүсэх эрсдэл бий болох, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө дутагдах

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж цаашид төлөвлөгдөөгүй зардал гаргахгүй байх

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Үндсэн хөрөнгийн ашиглалт

2.1. Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант онд худалдан авсан 1500.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, хэрхэн ашиглах нь тодорхойгүй байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, хөрөнгө алдагдах

2.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж тус хөрөнгийн ашиглалтыг сайжруулан холбогдох албан тушаалтанд хариуцуулах

2.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

3.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

3.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	ГХБХБ-ын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/79/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	ГХБХБ-ын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийг хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	3883.4	Төлбөрийн акт бичих	Дарга, Нягтлан бодогч	Э.Дөлбадрал Г.Эсбаатар
2	Данс бүртгэлд тусгагдсан тээврийн хэрэгслийг бусад байгууллагад ашиглуулсан.	68989.8	Албан шаардлага өгөх		
3	Газрын гэрчилгээ олголттой холбоотой үнэт цаасны тооцоо бодоогүй	6618,4	Албан шаардлага өгөх		
4	Бичиг хэргийн стандартыг мөрдөөгүй, албан тушаалд заасан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн	0	Албан шаардлага өгөх		
5	Цалингийн сангаас шүүхийн шийдвэрээр цалин олгосон	3715.5	Зөвлөмж өгөх		
6	Хэрхэн ашиглах нь тодорхой бус компьютер худалдан авч хөрөнгийн бүртгэлд бүртгэж хүлээн авсан	1500.0	Зөвлөмж өгөх		
7	И баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		84707.2			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

